

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго:

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтын хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоох, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг **Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг** хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

3.1. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан **Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд** нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 1 зорилт бүхий 1 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

Зорилт 1.5. *“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ”* зорилтын хүрээнд:

- 1.5.5. Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох /ЗГҮАХ-2.5.5/;

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

Зорилт, арга хэмжээний дугаар	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт /Хувиар/
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО			

1.5.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ.		
1.5.5.	Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох /ЗГҮАХ-2.5.5/;	1	85
Нийт		1	85

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгээр:

- Зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шаардагдах тооцооллыг хийж, холбогдох газруудад хүргүүлсэн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрээгүй боловч, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч ажил хийгдэж буй 85 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна.

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу **Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд** нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 85.0 хувь буюу “**Тодорхой үр дүнд хүрсэн**” гэж дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хавсаргав.

Хянаж баталгаажуулсан:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНХУЯГ

Үнэлгээ хийж, тайлан боловсруулсан:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Н.БОЛОРМАА